

ҮЗЭН ЯДАЛТЫГ ДЭВЭРГЭСЭН ҮГ ХЭЛЛЭГ

Олон улсын хүний эрхийн хуулийн дагуу улс орнууд ялгаварлан гадуурхал, дайсагнал, хүчирхийллийг өдөөн турхирсан үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийг хориглох үүрэгтэй. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дараах зүйлийг заасан байдаг:

Үндэстэн, арьс өнгө, шашныг үзэн ядах үзлийг сурталчилсан, үүн дотор ялгаварлан гадуурхал, дайсагнал, хүчирхийллийг өдөөн турхирсан аливаа үйл ажиллагааг хуулиар хориглох ёстой.

Олон улсын бусад гэрээнд ч мөн улс орнуудаас үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийг хориглох эсвэл хариу үйлдэл үзүүлэхийг шаарддаг. *Арьс өнгөөр ялгаварлан гадуурхахыг устгах тухай конвенцод* (CERD) арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, үзэн ядах үзэл санааг тараах, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийг өдөөх, арьс өнгөөр ялгаварлан хүчирхийлэх үйлдэлд өдөөн хатгасан үйлдлийг хориглохыг улс орнуудад шаарддаг.⁴ Үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэг нь хоморголон устгахыг өдөөн хатгасантай ижил хэмжээнд хүрсэн бол энэ нь Олон улсын эрүүгийн шүүхийн эрх мэдлийн хүрээний олон улсын гэмт хэрэг болдог ба Геноцидийн конвенцод улс орнуудад “олон нийтэд болон шууд байдлаар геноцид үйлдэхэд өдөөн турхирахыг” хориглохыг шаарддаг.⁵ Олон улсын бусад стандартууд мөн үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгд анхаарал хандуулдаг, тухайлбал НҮБ-ын Уугуул иргэдийн эрхийн тухай тунхаглалд уугуул иргэдийг арьс өнгө, үндэс угсаагаар ялгаварлан гадуурхахыг дэмжсэн эсвэл өөгшүүлсэн суртал ухуулгын асуудлыг шийдвэрлэхийг улс орнуудад уриалсан байдаг.⁶

Үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэг нь онилсон хүмүүсийнхээ тэгш байдалд халддаг, энэ нь хүний хамгийн эрхэм дээд эрхийн нэг билээ. Мөн түүнчлэн, үзэн ядалтад өртсөн бүлгийн олон

⁴ 4 21 December 1965, in force 4 January 1969, Article 4

⁵ *Convention on the Prevention and Punishment of the Crime of Genocide*, 9 December 1948, in force 12 January 1951, Article III(c); and *Rome Statute of the International Criminal Court*, 18 July 1998, in force 1 July 2002, Article 25(3)(e).

⁶ ⁵⁶ General Assembly Resolution 61/295, 13 September 2007, Article 8(2)(e), undocs.org/A/RES/61/295

нийтийн орчинд чөлөөтэй оролцох, тэр дундаа үзэл бодлоо илэрхийлэх эрх, мэдээлэл олж авах эрхээ чөлөөтэй хэрэгжүүлэхэд саад болдог. Тиймээс үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгтэй холбоотой хууль тогтоомж нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж байгаа хэдий ч энэ эрхээ хэрэгжүүлэхэд бас дэмжлэг болдог. Үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийн тухай хуулийг зөв боловсруулж, хэрэгжүүлж чадвал үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, үзэн ядалтаас ангид байх эрх нь хоорондоо өрсөлдөхөөс илүү аль алийгаа нөхдөг эрх юм.

Үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийг хориглох үүрэг нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 3-т заасан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах шалгуурыг дагаж мөрдөх төрийн үүрэг хариуцлагаас чөлөөлөхгүй. Үзэл бодлоо илэрхийлэхийг хязгаарлах гурван хэсэгт шалгуурт заагдсан үндэслэлүүдийн нэг нь бусдын эрхийг хамгаалах явдал юм. Хүн бүр үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэг, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхтэй, тиймээс үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгт хариу үйлдэл үзүүлэх нь гурван хэсэгт шалгуурын хоёрдугаар хэсэгт заасны дагуу үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах зөв үндэслэл болно. Тиймээс улс орнууд олон улсын хүний эрхийн хуулиар үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийг хязгаарлаж *болохын* сацуу Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон бусад холбогдох олон улсын гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх шаардлагын хэмжээнд хязгаарлах *ёстой* юм. Гэвч үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийн тухай хууль нь "хуульд заасан" ("provided by law") байх ёстой бөгөөд шаардлагатай, мөн зохистой байх ёстой.

19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг болон 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүрэг хариуцлагын аль алиныг нь хангасан үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийн тухай хууль, бодлогыг батлахыг эрмэлзэж буй улс орнуудад олон улсын стандарт удирдамж болдог.

Үүнд, эхний ээлжид хамгийн чухал зүйл бол 20 дугаар зүйлийн 2-т "өдөөн хатгалгын" тодорхой хэдхэн төрлийг, чухамдаа үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийг жинхэнэ бүрдүүлдэг зүйлийг хориглохыг шаарддаг. Бусад төрлийн үл тэвчих үг хэллэгийн тухайд эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэхээс илүүтэй олон талт бодлогоор хариу арга хэмжээ авах, мэдлэг/боловсролыг дээшлүүлэх байдлаар шийдвэрлэх ёстой. Гэвч, "дан ганц хуулийн хориг"-оор "хүний үзэн ядах мэдрэмжийг" үгүй хийж чадахгүй гэдгийг засгийн газрууд ойлгох ёстой.⁷ Дараах зураглал (схем)-аар үл тэвчих болон ялгаварлан гадуурхсан үг хэллэгийн ямар төрөлд ямар хууль тогтоомж, бодлогын хариу арга хэмжээ авах нь тохиромжтой болохыг зохицуулсан олон улсын эрх зүйн харьцангуй хатуу дүрмийг тоймлон харуулав.

⁷ Report of the UN Special Rapporteur on Freedom of Expression, 7 September 2012, para. 32, undocs.org/A/67/357.

- Өдөөн хатгасан үзэн ядалтыг сурталчлах: Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 20 дугаар зүйлийн 2-т маш тодорхой төрлийн үг хэллэг, тухайлбал ялгаварлан гадуурхал, дайсагнал, хүчирхийлэлд турхирсан үзэн ядалтыг сурталчлахыг хуулиар хориглохыг шаарддаг.
 - Улс орнууд энэ төрлийн үг хэллэгийг хориглох ёстой. Үүнийг хийх ердийн арга зам нь эрүүгийн гэмт хэргээр дамжуулах юм, гэхдээ үүнийг хатуу стандартын дагуу хийх ёстой бөгөөд доор авч үзэх болно. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан бүх хязгаарлалтын нэгэн адил үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгтэй холбоотой аливаа шийтгэл нь зохистой байх ёстой бөгөөд бусдаар ийм дүрэм нь 19 дүгээр зүйлийн 3-т заасан гурван хэсэгт шалгуурт нийцэх ёстой.
 - Геноцидийн конвенцод улс орнуудаас геноцид үйлдэхийг шууд болон олон нийтэд өдөөн турхирсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг шаарддаг. Улс орнууд ийм хуульдаа геноцидийг өдөөн турхирсан гэмт хэргийн бүрэлдэхүүн хэсгүүдийг олон улсын эрх зүйн хүрээнд тусгасан байх ёстой.
- Үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгт тооцогдохгүй үл тэвчсэн, ялгаварлан гадуурхсан, өрөөсгөл үзэл бүхий үг хэллэг: бусад төрлийн үг хэллэг нь эрх тэгш байдлыг гутаасан, хор хөнөөлтэй, тэр ч байтугай арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, харийнхныг үзэн ядах шинжтэй ч хуулиар хориглох хэмжээнд хүрэхгүй.
 - Эрүүгийн шийтгэл хүлээлгэх, ялангуяа хорих ялаар шийтгэх нь ийм төрлийн үг хэллэгийг шийдвэрлэхэд тохирох хэрэгсэл биш юм.
 - Захиргааны торгууль, иргэний эрх зүйн арга хэмжээ зэрэг бусад шийтгэл тухайн нөхцөл байдлаас хамаарч, гурван хэсгээс бүрдсэн шалгуурын бүх шаардлагыг хангасан тохиолдолд тохиромжтой байж болно. Жишээлбэл, өргөн нэвтрүүлгийн болон тусгай зөвшөөрлийн дүрмээр Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 20 дугаар зүйлийн 2-т заасан үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгээс илүү өргөн хүрээнд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах контентыг зохицуулж болно. Ийм дүрмийг хараат бус зохицуулах байгууллагууд өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын талаарх олон улсын хүний эрхийн стандартын дагуу хэрэгжүүлэх ёстой бөгөөд үүнийг Эрх зүй, ардчиллын төвийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаарх сургалтын загвар материалд ерөнхийд нь товч тайлбарласан болно.⁸
 - Улс орнууд ийм төрлийн үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгтэй тэмцэхийн тулд шийтгэлийн бус олон арга хэмжээний талаар судлах ёстой. Жишээлбэл,

⁸ See https://www.law-democracy.org/live/wp-content/uploads/2022/12/Training-Materials-1.FOE_.format-1.pdf.

боловсролын салбарт арга хэмжээ авах, цөөнхөд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө хэрэгжүүлэх боломжийг олгох санаачилга хэрэгжүүлэх, эрх тэгш байдлын байгууллагыг бий болгох, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон ургалч үзэл, олон талт байдлыг дэмжих, ийм үг хэллэгтэй тэмцэх үр дүнтэй стратегийн талаар албан тушаалтнуудад сургалт явуулах, мөргөлдөөнийг шийдвэрлэх механизм, платформ бий болгох зэрэг байж болно.⁹ Улс орнууд эдгээр төрлийн үйл ажиллагаанд оролцох эерэг үүргийг хүлээж болно. *Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцод*, жишээ нь, арьс өнгөөр ялгаварлан гадуурхахад хүргэдэг өрөөсгөл үзлийн эсрэг “ялангуяа сурган хүмүүжүүлэх, боловсрол, соёл, мэдээллийн салбарт нэн даруй, үр дүнтэй арга хэмжээ авахыг” улс орнуудад тодорхой заасан байдаг.¹⁰

Үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийг эрүүгийн хуулиар хориглох

Үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгтэй холбоотой эрүүгийн гэмт хэргийн хуулиар хамгийн хатуу шийтгэл ногдуулдаг тул энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг онцгой хатуугаар хязгаарладаг. Иймээс олон улсын стандартад үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгтэй холбоотой эрүүгийн хууль 19 дүгээр зүйлийн 3-т заасан гурван хэсэгт шалгуурыг зөрчихгүйн тулд ямар шаардлага хангасан байх ёстой талаар дэлгэрэнгүй зааварчилгаа өгсөн байдаг. Жишээлбэл, үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийг хориглосон хууль нь 20 дугаар зүйлийн 2-т орсон элементүүдэд нийцэх ёстой. Олон улсын байгууллагууд эдгээр стандартыг дараах байдлаар тайлбарладаг:

- Үзэн ядалт гэдэгт “тодорхой бүлэгт чиглэсэн үл тэвчсэн шүүмжлэл, дайсагнал, жигшлийн хурц, үндэслэлгүй сэтгэл хөдлөл”-ийг ойлгох хэрэгтэй.
- Сурталчилгаа гэдэгт тодорхой бүлгийг үзэн ядах үзлийг олон нийтэд сурталчлах зорилготой санаа багтана .
- Өдөөн турхирах гэдэг нь ялгаварлан гадуурхах, дайсагнах, хүчирхийлэх “зайлшгүй эрсдэлийг бий болгож буй” үг, илэрхийлэл хэрэглэхийг хэлнэ.¹¹

Иймээс үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгтэй холбоотой эрүүгийн гэмт хэргийн хуульд санаа зорилгын талаар хангалттай тодорхой шаардлага тавигдах ёстой.¹² "Сурталчилгаа" гэдэгт гэмт

¹⁰ Note 4, Article 7.

¹¹ ¹¹ Энэхүү тодорхойлолтыг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба тэгш байдлын тухай Камдены зарчмын 12 дугаар зарчмаас гаргаж авсан ба Article 19 гэх байгууллагаас зөвшилцсөний дараа боловсруулжээ. Article 19, Камдены зарчим, 2009, <https://bit.ly/3UokrWW>. Үүнийг Рабатын үйл ажиллагааны төлөвлөгөөний 5-р тэмдэглэлийн 9-р тэмдэглэлд баталсан байдлаар эш татсан; Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан, 2019 оны 10-р сарын 9, догол 13, undocs.org/A/74/486; болон Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн тайлан, 2012 оны 9-р сарын 7, догол 44, undocs.org/A/67/357.

¹² ¹² See also Special international mandates on freedom of expression, Joint Statement on Racism and the Media, 27 February 2001, <https://www.osce.org/files/f/documents/f/1/40120.pdf>.

хэргийн нэг бүрэлдэхүүн хэсэг болох үзэн ядах санаа агуулагдаж байгаа бөгөөд энэ нь үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгтэй тэмцэх, түүний гарал үүслийг тодорхойлох зорилгоор хэлэлцэж буй хүмүүсийг, тухайлбал, эрдэмтэн судлаачид, идэвхтнүүдийг хамгаалдаг юм. Үүний нэгэн адил, учирч болзошгүй байдлын шаардлага (requirement of imminence) буюу үг хэллэг болон учирч болзошгүй хохирлын хооронд хангалттай учир шалтгааны холбоо байх нь үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгтэй холбоотой эрүүгийн хуулийг урвуулан ашиглахаас сэргийлдэг. Энэ нь маргаантай яриа болон түүнээс үүдэх болзошгүй гэм хорын хоорондын хэт сулруулсан уялдаа холбоогоор дамжин биелдэг.

20-р зүйлийн 2-т зөвхөн үндэстэн, арьс өнгө, шашинд үндэслэсэн үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийн талаар заасан байдаг бол олон улс оронд өөр тодорхойлогчоор тогтоосон бүлгийг онилсон үзэн ядсан үг хэллэгийг хориглодог. Энэ нь зүйтэй бөгөөд бусад бүлгийн эрхийг хамгаалахад шаардлагатай байж болох ч ингэхдээ ялгаварлан гадуурхах тухай олон улсын хүний эрхийн стандартыг баримжаа болгон ашиглах ёстой. Жишээлбэл, зөвхөн албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн угсаатны бүлгийг хамгаалах нь асуудал дагуулах болно, мөн зарим албан байгууллагыг ("цэргийнхэн" эсвэл парламентын гишүүд гэх мэт) тусгай хамгаалалтад оруулах нь адил үр дагавартай байх юм.

Хүний эрхийн хороо, *Раббае Нидерландын эсрэг*

Цагаачлалын эсрэг үзэл бодлоороо алдартай Голландын улс төрч Гирт Вилдерс лалын шашинтнуудын эсрэг өдөөн хатгасан олон мэдэгдэл хийжээ. Эдгээр мэдэгдлийн үндсэн дээр түүнийг "шашин шүтлэг, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах, үзэн ядахыг өдөөн хатгасан" гэх зэрэг эрүүгийн хэрэгт буруутгаж байсан ч эцэст нь цагаатгасан. Парламентын гишүүн, лалын шашинтан ноён Раббае болон дарамт шахалт, ялгаварлан гадуурхалтад өртөж байсан өөр хоёр лалын шашинтан, дээрх хэргийг цагаатгасан нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 20 дугаар зүйлийн 2-т заасан тэдний эрхийг зөрчсөн гэж үзэж Хүний эрхийн хороонд гомдол гаргажээ.¹³

Хороо 20 дугаар зүйлийн 2-т хүн бүр үзэн ядалт, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хамгаалдаг гэдгийг нотолсон боловч улс орнууд үзэл бодлоо илэрхийлэх тодорхой хэлбэрийг л хориглох хууль ёсны үүрэгтэй гэдгийг тэмдэглэв. 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон бусад эрхийг хамгаалахын тулд "хязгаартай боловсрогдсон" бөгөөд олон нийт, улс төрийн асуудлаар санал бодлоо чөлөөтэй солилцох нь чухал, мөн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь "ихэд доромжилсон" үг хэллэгийг ч хүртэл хамгаалдаг гэдгийг Хороо онцолжээ. Мөн 19, 20 дугаар зүйл нь нэг нь нөгөөгөө харилцан нөхдөг мөн чанартай, 20 дугаар зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэх хориг нь 19 дүгээр зүйлд заасан гурван хэсэгт шалгуурт нийцэх ёстой гэдгийг баталжээ.¹⁴

Хороо Нидерланд улс үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийг эрүүгийн хуулиар хориглодог болохыг тогтоож, хохирогчдыг хэрэг үүсгэж, шүүхийн үйл явцад оролцохыг зөвшөөрсөн. Энэ хэрэгт ноён Вилдерс яллагдагчаар татагдаж, шүүх түүний мэдүүлгийг үнэлэн нарийвчилсан дүгнэлт гаргасан байв. Нидерланд улс үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийг хориглох, гомдол гаргачдад үр дүнтэй эрх зүйн хэрэгслийг баталгаажуулахын тулд шаардлагатай, зохистой арга хэмжээ авсан байна гэж Хороо тогтоожээ. 20 дугаар зүйлийн 2-т үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгт буруутгагдаж буй хүмүүсийг "хараат бус, шударга шүүх заавал яллах" үүргийг улс орнуудад ногдуулаагүй тул Хороо Нидерланд улс 20-р зүйлийн 2-ыг зөрчөөгүй гэж үзсэн.¹⁵

Ялгаварлан гадуурхал, дайсагнал, хүчирхийлэлд өдөөн хатгасан үйлдлийг бүрэлдүүлэгч үндэстэн, арьс өнгө, шашны үзэн ядалтыг сурталчлахыг хориглох тухай Рабатын үйл ажиллагааны төлөвлөгөө бол Хүний эрхийн дээд комиссарын газраас 2011, 2012 онд зохион байгуулсан, шинжээчдийн хэд хэдэн семинарын үр дүнд бий болсон баримт бичиг юм. Энэ баримт бичигт үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийн гэмт хэргийн ял хууль ёсонд нийцсэн эсэхийг тодорхойлох зургаан хэсэгтэй “босго шалгуур”-ыг тусгасан юм. Рабатын төлөвлөгөөнд шалгуурыг шүүгчдэд зориулсан гарын авлага болгон боловсруулсан боловч бусад нөхцөл байдалд ч ач холбогдолтой болжээ. Жишээлбэл, Африк дахь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зарчмын тунхаглалд улс орнууд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхээ шийдэхдээ эдгээр зургаан хүчин зүйлийг харгалзан үзэх ёстой гэж

¹³ *Rabbae v. The Netherlands*, 14 July 2016, Communication No. 2124/2011, undocs.org/CCPR/C/117/D/2124/2011.

¹⁴ *Ibid.*, para. 10.4.

¹⁵ *Ibid.*, para. 10.7.

заасан байдаг.¹⁶ Энэхүү босго шалгуурын зургаан хүчин зүйл нь:

- Нөхцөл байдал: нийгэм, улс төрийн нөхцөлийг оролцуулан, уг нөхцөл байдал нь тухайн үг хэллэг ялгаварлан гадуурхах, дайсагнах, хүчирхийлэх явдалд өдөөн турхирч болох эсэх, мөн зорилгыг тогтооход хамаатай байж болох талаар үнэлгээ хийхэд ашиглагдах ёстой.
- Илтгэгч: илтгэгчийн байр суурь, статусыг, ялангуяа сонсогчдын хувьд, авч үзэх ёстой.
- Зорилго, санаа: үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгт холбоотой хэргээр шийтгэхэд зүгээр нэг хайхрамжгүй эсвэл болчимгүй үйлдэл биш, тодорхой санаа агуулсан үйлдэл байх шаардлагатай. 20 дугаар зүйлийн 2 дахь заалт нь хор хөнөөлтэй материал тараах төдий тухай бус, харин хор хөнөөл учруулахыг сурталчлах, эсвэл өдөөн турхирах тухай юм гэдгийг анхаарах хэрэгтэй.
- Агуулга, хэлбэр: үг хэллэгийн агуулга, хэлбэр нь дүн шинжилгээ хийх, ялангуяа өдөөн хатгалга байгаа эсэхийг тогтооход мэдээлэл болох ёстой. Ийм дүн шинжилгээний жишээ нь үг хэллэг нь шууд утгатай байсан эсэх, хэр өдөөн хатгасан, мөн гол гол санааг хэр хэмжээнд тунгаан бодсон байна гэх зэргийг багтааж болно.
- Хэлсэн үгийн цар хүрээ: хэлсэн үгийн цар хүрээ, үүнд хэлсэн үгийн хамарсан хүрээ, хэлсэн үгийг хэрхэн тараасан, сонсогчдын тоо, олон нийтийн өмнө хэлсэн эсэх зэрэг хүчин зүйл хамаарна.
- Магадлал, үүний дотор болох гэж буй нь тодорхой байдал: аль болох шууд учир шалтгаан байх ёстой, тухайлбал үг хэллэг нь үнэхээр хор хөнөөл өдөөх үндэслэлтэй магадлалтай байх (гэвч хор хөнөөл нь бодитоор учирсан байх шаардлагагүй).¹⁷

Жишээ дурдахад, НҮБ-аас өөрийн талбарт ажиллаж байгаа хүмүүст үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийн эсрэг зохих хариу арга хэмжээг боловсруулахдаа Рабатын төлөвлөгөөний хүчин зүйлсийг удирдамж болгон ашиглахыг санал болгодог.

¹⁷United Nations Strategy and Plan of Action on Hate Speech: Detailed Guidance on Implementation for United Nations Field Presences, September 2020, pg. 17, <https://bit.ly/3zQubBt>. All summarising language found at the Rabat Plan of Action, note 9, para.29.

Европын хүний эрхийн шүүх: *Жерсилд Данийн эсрэг*

Рабатын төлөвлөгөөнд тодорхойлсон зургаан хүчин зүйл нь зүгээр нэг гараад ирээгүй юм: тэдгээр нь хүний эрхийн бусад эрх бүхий байгууллагаас тогтоосон зарчим болон өмнө нь хүлээсэн амлалт, стандартыг тусгасан болно. Жишээлбэл, Европын Хүний эрхийн шүүх Рабатын төлөвлөгөөг боловсруулахаас өмнө олон хэргийг шийдвэрлэсэн бөгөөд ингэхдээ дүн шинжилгээнд тулгуурладаг байсан нь сүүлд уг Төлөвлөгөөний зургаан хүчин зүйлд тусгалаа олсон юм. Үүнийг 1994 оны Их танхимын шийдвэр болох *Жерсилд Данийн эсрэг* шүүх хурлын шийдвэрээс харж болно. Энэ хэрэгт Дани улсын сэтгүүлч холбогдсон бөгөөд, тэрээр арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэлтэй залуучуудтай ярилцлага хийж, тэдний арьс өнгөөр ялгаварлан гадуурхсан мэдэгдлүүдийг нэвтрүүлэгтээ оруулжээ. Түүнийг арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийг хориглодог Данийн Эрүүгийн хуулийн зүйл ангиар буруутгаж, торгууль ногдуулсан.¹⁸

Шүүх шийтгэлийг "хуульд заасан" бөгөөд бусдын эрхийг хамгаалах хууль ёсны зорилготой байна гэж үзсэн. Гэвч энэ зорилгыг хамгаалах "шаардлага" байгаагүй, тиймээс сэтгүүлчийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн байна. Энэ шийдвэрийг гаргахад хэд хэдэн хүчин зүйл хамааралтай болохыг шүүх тогтоосон бөгөөд тэдгээрийн ихэнхийг Рабатын төлөвлөгөөнд тодорхойлсон хүчин зүйлсийн дагуу ангилж болно:

- Зорилго, санаа: сэтгүүлч хөтөлбөрийг эмхэтгэсэн зорилго нь арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл биш, энэ нь Шүүхийн "түлхүүр асуулт" байсан.¹⁹
- Илтгэгч: сэтгүүлч өөрөө арьс өнгөөр ялгаварлан гадуурхсан мэдэгдэл хийгээгүй, харин бусдын мэдэгдлийг тараасан төдий байгаа нь чухал гэж шүүх үзсэн.²⁰
- Агуулга, хэлбэр: нэвтрүүлэг нь "Данийн нэр хүндтэй мэдээллийн хөтөлбөр"-ийн хэсэг байсан бөгөөд ярилцлага авагч ярилцлага өгсөн хүмүүсээс зай барьсан нь тодорхой байна. Хөтөлбөр нь мөн Дани улс дахь арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн талаарх хэлэлцүүлгээс эхэлсэн бөгөөд ерөнхийдөө залуучуудын арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийг нийгмийн эсрэг ерөнхий үзэл санааны нэг хэсэг болгон дүрсэлсэн; арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийг илт буруушаагаагүй ч шүүх үүнийг шийдвэрлэх хүчин зүйл гэж үзээгүй, ингэхдээ нэвтрүүлгийн ерөнхий өнгө аяс, редакцын сонголтыг богино нэвтрүүлэгт хийх ёстой байдаг зэргийг харгалзан үзсэн.²¹
- Нөхцөл байдал: бусдын үзэл бодлыг олон нийтэд түгээснийх нь төлөө сэтгүүлчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь хэвлэлийн нийгэм дэх үүргээ биелүүлэх чадварт ерөнхийд нь нөлөөлнө гэж шүүх санаа зовж байгаагаа илэрхийлэв. Хязгаарлагдмал хэмжээний торгууль байсан ч сэтгүүлчид ногдуулах нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд илүү ноцтой үр дагавар авчрах боломжтой юм.²²

¹⁸ 23 September 1994, Application No. 15890/89, <https://hudoc.echr.coe.int/eng/?i=001-57891>.

¹⁹ *Ibid.*, paras. 31 and 36.

²⁰ *Ibid.*, para. 31.

²¹ *Ibid.*, para. 34.

²² *Ibid.*, para. 35.

Хүний эрхийн гэрээ хоорондын ялгаа

Үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэг бол хүний эрхийн өөр өөр гэрээ өөр өөр хандлагыг баримталдаг салбар юм. Тухайлбал, арьс өнгөөр ялгаварлан гадуурхахыг устгах тухай конвенцын (АӨЯГУТК) 4-р зүйлд улс орнуудаас арьс өнгөөр ялгаварлах үзэл, үзэн ядалтад тулгуурласан үзэл санааг түгээхийг хориглохыг шаарддаг, гэхдээ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 20 дугаар зүйлийн 2-г тусгагдсан өдөөн хатгах үйлдлийн талаар тодорхой шаардлага тавьдаггүй.

Гэвч АӨЯГУТК -д улс орнууд үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийн талаарх дүрэм журмыг батлахдаа *Хүний эрхийн түгээмэл тунхаглал*²³ заасан зарчмуудыг "зохих ёсоор харгалзан үзэх" ёстой гэж заасан байдаг. Мөн Арьс өнгөөр ялгаварлан гадуурхахыг устгах хороо энэ заалтыг тайлбарлахдаа үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний стандарт нь "үг хэллэгийг хууль ёсны дагуу хязгаарлахын тулд баримтлах хамгийн их хамааралтай зарчим" байх ёстой гэж заасан.²⁴ Хороо, үүний адилаар эрүүгийн шийтгэлийг зөвхөн хүнд тохиолдолд ногдуулах ёстой бөгөөд "хууль ёсны, зохистой, зайлшгүй байх зарчмыг баримтлах" ёстой гэж мэдэгдсэн.²⁵ Түүнчлэн, Рабатын төлөвлөгөөний босго шалгуурын өөрчлөгдсөн хувилбарыг хүлээн зөвшөөрсөн, гэхдээ АӨЯГУТК-д өдөөн хатгасан бус гэмт хэргийн хувьд зорилго болон болох гэж буй нь тодорхой байдал зэрэг хүчин зүйлсийг хассан.²⁶ Энэ тал дээр АӨЯГУТК болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад орсон үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийн тухай заалтуудын хооронд "нийтлэг тайлбар"²⁷ байгааг харж болно. Гэвч АӨЯГУТК босго шалгуур нь бага, өдөөн хатгасан бус арьс өнгөөр ялгаварлан гадуурхсан үг хэллэгийг хориглохыг уриалсаар байна. Хоёр гэрээний дагуу хүлээсэн үүргийг зохицуулахын тулд бид АӨЯГУТК-ийн 4-р зүйлд заасны дагуу, хэрэв улс орнууд өдөөн хатгасан бус арьс өнгөөр ялгаварлан гадуурхсан үг хэллэгийг хоригловол, шийтгэл нь эрүүгийн бус, захиргааны шинж чанартай байх ёстойг санал болгож байна. Энэ нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийн тухай хуульд тавигддаг өндөр стандартыг хэрэглэхээс зайлсхийхийн тулд юм.

Үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийн талаарх үүрэг хариуцлагыг тайлбарлахтай холбоотой бүс нутгийн ялгаа бас байдаг. Өдийг хүртэл Африк, Америкийн хүний эрхийн шүүхүүд үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийг харьцангуй ховор авч үзсэн бол Европын хүний эрхийн шүүх энэ сэдвээр өргөн хүрээтэй хууль эрх зүйн орчин бүрдүүлжээ. Энэхүү хууль эрх зүйн орчинд Европын шүүх үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгтэй тэмцэхдээ хүний эрхийн бусад томоохон гэрээнд тусгагдсан стандартаас илүүтэйгээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахыг хүлээн авах хүсэлтэй байгаагаа харуулж байна.²⁸ Үг хэлэхийг хязгаарлахыг илүүд үздэг энэ

²³ UN General Assembly Resolution 217A (III), 10 December 1948.

²⁴ CERD, note 10, Article 4; and General Comment No. 35, 26 September 2013, para. 19, undocs.org/CERD/C/GC/35.

²⁵ *Ibid.*, para. 12.

²⁶ *Ibid.*, paras 15 and 16.

²⁷ Report of the UN Special Rapporteur on freedom of expression, note 11, para. 15.

²⁸ For a comparative discussion of this, see Evelyn Aswad and David Kaye, “Convergence & Conflict: Reflection on Global and Regional Human Rights Standards on Hate Speech”, *Northwestern Journal of Human Rights*, 7 July 2022, <https://bit.ly/3zIhLLN>.

хандлагын нэг эх сурвалж нь *Европын Хүний эрхийн тухай конвенцын* “эрхийг урвуулан ашиглах” заалт юм.²⁹ Шүүх энэхүү заалтыг конвенцын “үндсэн үнэт зүйлсийг” сүйтгэж болзошгүй зарим төрлийн үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хамгаалалтаас хасах утгаар тайлбарласан, энэ нь гурван хэсэгт шалгуурыг хэрэглэхгүй гэсэн үг юм.³⁰ Энэ бол олон улсын хүний эрхийн хуульд хандах онцгой хандлага юм, уг нь энэ хуулиар хэлсэн бүх үгийг хамгаалах нь хэвийн бөгөөд дараа нь хязгаарлахын тулд гурван хэсэгт шалгуурыг ашигладаг. Европын системд үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгтэй холбоотой хэргийг авч үзэхдээ хуульчид энэхүү онцгой хандлагын талаар санаж явах хэрэгтэй.

Нийгмийн зүтгэлтэн

Үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийг нэр хүндтэй нийгмийн зүтгэлтэн хүн хэлэх нь ялангуяа хор хөнөөлтэй бөгөөд ингэснээр үзэн ядалт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг өдөөх магадлал илүү өндөр болж болох юм. Нийгмийн зүтгэлтнүүд жирийн хүмүүсээс илүү олон сонсогчийг хамардаг бөгөөд тэдний үг илүү нөлөөтэй байж болно. Ийм учраас Рабатын төлөвлөгөөнд илтгэгчийн байр суурь, статусыг босго шалгуурын нэг хүчин зүйл гэж үздэг. Европын хүний эрхийн шүүх ч үүнтэй төстэй үндэслэлийг гаргасан. Жишээлбэл, олныг арьс өнгөөр ялгаварлан гадуурхсан уриа лоозон хашхирахыг уриалсан алдарт хөл бөмбөгчинд торгууль ногдуулсныг хууль ёсны болохыг хүлээн зөвшөөрсөн. Учир нь тоглогчийн алдар нэр, үлгэр дуурайл болох статусыг харгалзан үзвэл тэрээр өөрийн зан үйлийн болзошгүй хор хөнөөлийг мэддэг байх ёстой.³¹

Улс төрийн удирдагчид болон төрийн албан хаагчид ч үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэг хэрэглэхгүй байх онцгой үүрэг хариуцлага хүлээдэг. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад тусгагдсан үүрэг нь төрийн бүх шатны бүх салбарт хамаарна, үүнд гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх байгууллага, мөн үндэсний, бүс нутаг, орон нутгийн түвшний байгууллага зэрэг багтана.³² Улс төрчид болон төрийн албан хаагчид ч мөн арьс өнгөөр ялгаварлан гадуурхсан үг хэллэгээс зайлсхийх хэрэгтэй. АӨЯГУТК-д энэхүү үүргийг тодорхой нотолж, улс орнууд “үндэсний болон орон нутгийн төрийн эрх баригчид, төрийн байгууллагад арьс өнгөөр ялгаварлан гадуурхахыг дэмжих, өдөөн турхирахыг зөвшөөрч болохгүй”³³ гэж заасан байдаг.

Улс орнууд үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгтэй тэмцэхийн төлөө ажиллах эерэг үүрэг хүлээдэг, харин уг үг хэллэгээс зайлсхийх төдий ажиллаж болохгүй. Ерөнхийдөө Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын дагуу улс орнууд "хууль тогтоох, шүүх,

²⁹ 4 November 1950, E.T.S. No. 5, in force 3 September 1953, <http://conventions.coe.int/Treaty/en/Treaties/Html/005.htm>. 17-р зүйлд: “Энэхүү конвенцын аль ч зүйлийг ... энэхүү баримт бичигт заасан, аливаа эрх, эрх чөлөөг устгахад чиглэсэн аливаа үйл ажиллагаа эрхлэх, аливаа үйлдэл хийх эрхтэй, эсвэл Конвенцод заасан хэмжээнээс илүү хэмжээгээр хязгаарлах эрхтэй гэсэн утгаар тайлбарлаж болохгүй” гэж заасан.

³⁰ Хамгаалалтаас хасагдсан үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийн төрлийн хураангуйг энд үзнэ үү: European Court of Human Rights Press Unit, Factsheet - Hate Speech, June 2022, https://www.echr.coe.int/documents/fs_hate_speech_eng.pdf.

³¹ *Šimunić v. Croatia*, 22 January 2019, Application No. 20373/17, para. 45, <https://bit.ly/3EfoZtH>.

³² Human Rights Council, General Comment No. 31, 29 March 2004, para. 4, <https://bit.ly/3FTIPM3>.

³³ CERD, note 4, Article 4(c).

захиргааны, боловсролын болон бусад зохих арга хэмжээг авах" эерэг үүрэг хүлээдэг, үүнд уг пактаар хүлээх үүрэг хариуцлагын талаар төрийн албан тушаалтнуудын мэдлэгийг дээшлүүлэх үүрэг мөн орно.³⁴ Улс төрийн лидерүүд, намууд ч бас үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгтэй тэмцэх арга хэмжээ авах ёстой. Жишээлбэл, улс төрийн намууд өөрсдийн албан тушаалтан, нэр дэвшигчдээс үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэг гаргахгүйн тулд ёс зүйн дүрэм батлах эсвэл өөр арга хэмжээ авч болно.³⁵

Төрийн бус субъектийн хийсэн үйлдэлд төрийн албан тушаалтан тайлбар хийж тэдний зан үйлийг урамшуулсан тохиолдолд улс орнууд тодорхой хэмжээний хариуцлага хүлээх тохиолдол байж болно. Хүний эрхийн хуулийн дагуу улс орнууд хувь хүмүүсийн үйлдэлд шууд хариуцлага

хүлээхгүй боловч хүний эрхийг хохироосон хувь хүний үйлдэлд хариу үзүүлэхгүй байх нь гэрээний үүргээ зөрчсөнтэй тэнцэх юм. Жишээлбэл, сэтгүүлчдийн эсрэг халдлага үйлдсэн нөхцөл байдалд улс орнууд ийм халдлагаас урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, яллах, нөхөн төлбөр олгох арга хэмжээ авах ёстой. Анхаарал татахуйц хоёр хэрэг дээр Америк хоорондын Хүний эрхийн шүүхээс Венесуэлийн эрх баригчид хэвлэл мэдээллийн хэрэгслийг дарамталж, халдлага үйлдсэн хэрэг, мөн үүнтэй хавсран төрийн албан хаагчид хэвлэл мэдээллийн эсрэг айлган сүрдүүлсэн мэдэгдэл хийснийг зохих ёсоор шалгаагүй тул Венесуэл улс хүний эрхийн талаар хүлээсэн үүргээ зөрчсөн гэж үзсэн байна.³⁶ Эдгээр нь үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгтэй холбоотой хэрэг биш байсан боловч, дараах тохиолдолд ижил төстэй үндэслэлийг хэрэглэж болох юм: дээд албан тушаалтнууд ялгаварлан гадуурхсан эсвэл үзэн ядсан мэдэгдэл хийсэн, эсвэл улс орнууд төрийн албан тушаалтан үзэн ядалтыг өдөөн хатгасан үг хэллэгтэй холбоотой эрүүгийн хариуцлага хүлээлгэхүйц хэрэг үйлдсэн нөхцөлд ял тулгаж чадахгүй байх, үгүй бол улс орнууд төрийн албан тушаалтны үзэн ядсан, ялгаварлан гадуурхсан үг хэллэгийн эсрэг өөр арга хэмжээ аваагүй (сургалт зохиох, захиргааны дотоод шийтгэлийн тогтолцоо бүрдүүлэх гэх мэт).

Нийгмийн зүтгэлтнүүд, ялангуяа улс төрийн зүтгэлтнүүд ч мөн хүн бүрийн адил үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Улс төрийн илтгэлийг зарим хүмүүс "хэт шүүмжлэлтэй, бүр доромжилсон" гэж үзэж болох ч улс төрийн илтгэл өндөр түвшний хамгаалалттай байдаг.³⁷ Үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийн түвшинд хүрэлгүйгээр нийгэм, улс төрийн эмзэг шинж чанартай асуудлаар үзэл бодлоо илэрхийлсэн нийгмийн зүтгэлтний мэдэгдлийг үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгтэй холбоотой үндэслэлээр хязгаарлаж болохгүй. Нийгмийн зүтгэлтнийг үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгтэй холбоотойгоор ялласан нь хууль ёсны эсэхийг үнэлэхдээ шүүх Рабатын төлөвлөгөөний босго шалгуурын зарчмын дагуу тухайн хүний статус, нөлөө, сонсогчдыг хамарсан хүрээ зэргийг харгалзан үзэх ёстой. Гэхдээ, хэлсэн үг нь улс төрийн мэтгэлцээний нэг хэсэг байсан эсэх нь тухайн нөхцөл байдалд хамааралтай хүчин зүйл байж болно. Европын Хүний эрхийн шүүх эдгээр асуудлыг хэрхэн дүгнэсэн тухай хоёр жишээг энд дурдъя.

³⁴ Article 2 of the ICCPR; and General Comment No. 31, note 32, para. 7.

³⁵ International mandates for promoting freedom of expression, 2021 Joint Declaration on Politicians and Public Officials and Freedom of Expression, 20 October 2021, para. 3(1).

³⁶ *Perozo and Others v. Venezuela*, 28 January 2009, Series C, No. 195, <https://bit.ly/3DL6WtX>; and *Ríos v. Venezuela*, 28 January 2009, Series C, No. 194, <https://bit.ly/3FR0eoS> (only available in Spanish).

³⁷ 2021 Joint Declaration on Politicians and Public Officials and Freedom of Expression, note 35, para. 2(a)(i).

Европын хүний эрхийн шүүх

Фере Бельгийн эсрэг: Бельгийн улс төрч өөрийн намын хэвлэлийн редактор хийдэг байв. Түүний нам харийнхныг үзэн ядсан уриа лоозон агуулсан цагаачлалын эсрэг нийтлэл тарааж, ялгаварлан гадуурхах бодлогыг сурталчилжээ. Бельгийн шүүх түүнийг парламентын гишүүний халдашгүй бүрэн эрхээсээ татгалзсаны дараа ялгаварлан гадуурхалт, үзэн ядалтад өдөөн хатгасан хэмээн буруутгаж, нийгэмд тустай ажил хийх, хорих ялыг тэнсэн харгалзах, парламентад ажиллах эрхийг 10 жилээр хасах шийтгэл оноожээ.³⁸

Европын хүний эрхийн шүүх Бельги улс, улс төрчийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зөрчөөгүй гэж үзжээ. Ял шийтгэл нь хуульд заасны дагуу, хууль ёсны зорилгод нийцсэн бөгөөд энэ зорилгод хүрэхэд зайлшгүй шаардлагатай байсан.³⁹ Шүүх, улс төрд үгээ чөлөөтэй хэлэх нь ардчилсан нийгэмд нэн чухал ач холбогдолтой гэдгийг онцлон тэмдэглэсэн ч парламентын гишүүн байх нь хувь хүнийг үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэг тараасны хариуцлагаас хамгаалахгүй гэдгийг онцлон тэмдэглэв. Хэрэв сонгуулийн үеэр нэр дэвшигчид гаднынхныг үзэн ядсан үг хэллэг хэрэглэвэл олон нийтээс хор хөнөөлтэй хариу үйлдэл үзүүлэх эрсдэлийг нэмэгдүүлж болох юм.⁴⁰ Шүүх ухуулах хуудсыг судалж үзээд тэдгээр нь арьс өнгөөр ялгаварлан гадуурхсан үзэн ядалтыг илт өдөөсөн болохыг тогтоож, Бельгийн шүүх парламентын гишүүнийг буруутгасан үндэслэлийг хүлээн зөвшөөрсөн байна. Шүүх мөн Бельгийн шүүхийн хорих ял оногдуулаагүй шийдвэрийг тэмдэглэж, шийтгэлийг зохистой бус гэж үзээгүй байна.⁴¹

Эрбакан Туркийн эсрэг: Туркийн шүүх Ерөнхий сайд асан нэгэнд үг хэлэхдээ үзэн ядалт, дайсагналд өдөөн хатгасан хэргээр нэг жил хорих, торгох ял оноосон. Түүнийг үг хэлэхдээ сүсэгтэн ба сүсэгтэн бус хүмүүсийн хооронд ялгаа гаргаж, бусад улс төрийн намуудыг Аллахын эсрэг байдалтай дүрсэлсэн гэсэн үндэслэлээр буруутгасан байна.⁴²

Европын Хүний Эрхийн Шүүх уг ялыг ноён Эрбаканы үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зөрчсөн гэж үзсэн байна. Яллагчийн зүгээс уг хэлсэн үг нь ямар нэгэн гарцаагүй аюул, эсвэл бодит эрсдэлд хүргэж болзошгүйг нотолсон гэсэн нотолгоог Турк улс гаргаагүй. Алдартай улстөрчид эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь зохистой шийтгэл байсангүй, тэр тусмаа ардчилсан нийгэмд улс төрийн мэтгэлцээнийг чөлөөтэй явуулах эрх ашгийг харгалзан үзэх хэрэгтэй байсан юм.

³⁸16 July 2009, Application No. 15615/07, <https://hudoc.echr.coe.int/eng?i=001-93626>, only in French but summarised in English at <https://bit.ly/3WBgDnf>.

³⁹ Энэ нь шүүх Европын конвенцод заасан "эрхээ урвуулан ашиглах" заалтыг өдөөсөн гэж үзсэн тохиолдол биш тул ердийн гурван хэсэгт шалгуурыг ашигласан.

⁴⁰ *Ibid.*, para. 77.

⁴¹ *Ibid.*, paras. 78-80.

⁴² 6 July 2006, Application No. 59405/00, <https://hudoc.echr.coe.int/eng?i=001-76232>; only in French but English summary at <https://bit.ly/3E3q9Iz>.

Геноцидийг үгүйсгэх

Ер нь түүхэн баримт, үйл явдлын талаар мэтгэлцэх, хэлэлцэх явдал нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хүрээнд хатуу хамгаалагдсан байдаг.⁴³ Хүний эрхийг ноцтойгоор зөрчсөн тухай, мөн геноцид зэрэг харгис хэрцгий гэмт хэргийн талаар олон нийтээр хэлэлцэж байх нь онцгой ач холбогдолтой юм. Олон нийтэд ийм үйл явдлын талаарх мэдлэгийг түгээх, цаашид дахин давтагдуулахгүй байх сонирхол өндөр байгаа учир ийм хэлэлцүүлэг хийж байх нь бүр ч чухал юм. Ийм учраас геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг эсвэл үүнтэй төстэй харгис хэрцгий явдлын талаарх маргааныг хязгаарласан хуулиуд нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд санаа зовоход хүргэж болзошгүй юм.

Гэвч, зарим маш хязгаарлагдмал нөхцөл байдалд геноцидийг үгүйсгэх явдал нь үзэн ядалтыг дэвэргэсэн үг хэллэгийн хэлбэрээр илэрч болно. Нягт боловсруулсан геноцидийг үгүйсгэх тухай хуулийн дагуу, ялангуяа Холокостыг үгүйсгэхэд чиглэсэн хуулиар ял шийтгэл оноох нь 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн шалгуурыг давах магадлалтай. *Фориссон Францын эсрэг* шүүх хуралдаанд Хүний эрхийн хороо нэгэн эрдэмтний хэргийг хянан хэлэлцжээ. Уг эрдэмтэнд нацист дэглэмийн үйлдлийг эрүүгийн гэмт хэрэг гэж үздэг Францын хуулийн дагуу торгууль ногдуулсан байна. Шүүхүүд нацист дэглэмийн үйлдлийг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг гэж үздэг. Эрдэмтэнд шийтгэл ногдуулахдаа нацистуудын хүн устгах зориулалттай хийн камерыг байгаагүй гэж үгүйсгэсэн түүний үгэнд үндэслэжээ. Холокостыг үгүйсгэх энэ хэлбэр нь Франц дахь еврей эсрэг үзлийн "гол хэрэгсэл" байсан, иймээс еврей нийгэмлэгийн антисемитизмээс айх айдасгүй амьдрах эрхийг хамгаалахын тулд уг шийтгэл нь зайлшгүй шаардлагатай гэж тус Хороо үзсэн.⁴⁴

Европын Хүний эрхийн шүүх ч Холокостыг үгүйсгэсний төлөөх ялыг хүчинтэй гэж ерөнхийд нь хүлээн зөвшөөрсөн.⁴⁵ Нөгөө талаар, Европын шүүхийн Их танхим Холокостыг үгүйсгэх нь онцгой тохиолдол байж магадгүй гэж мэдэгдсэн. *Перинчек Швейцарийн эсрэг* шүүх

хуралдаанаар Швейцар улс турк иргэнийг Армений геноцидийг үгүйсгэсэн хэргээр ялласан нь түүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн гэж үзсэн. Их танхимын шийдвэр нь хэд хэдэн хүчин зүйлд үндэслэсэн боловч Шүүх Холокостыг үгүйсгэсэн хэргийг тодорхой ангилалд хамааруулж байгаагаар илэрхийлэв. Жишээлбэл, тодорхой бүлэг хүмүүст сэтгэлийн шарх учруулан нөлөө үзүүлсэн үйл явдлын тухай дурдсан мэдэгдлүүд нь тухайн бүлгийн нэр төр, эрхэм чанарт хангалттай хохирол учруулж болох нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахыг зөвтгөх үндэслэл мөн гэдгийг Их танхим хүлээн зөвшөөрсөн. Гэвч, ийм тохиолдолд, учирсан тодорхой хор хөнөөлийн баримт, нотолгоо байх шаардлагатай гэж Их танхим үзсэн (энэ тохиолдолд тийм хор хөнөөлийн нотолгоо гаргаагүй гэж үзсэн).

⁴³ Human Rights Committee, General Comment No. 34, 12 September 2011, para. 49. See also *Lehideux and Isorni v. France*, 23 September 1998, Application No. 24662/94 (European Court of Human Rights), and Committee on the Elimination of Racial Discrimination, General Comment No. 35, note 24, para. 14.

⁴⁴ *Faurisson v. France*, 8 November 1996, Communication No. 550/1993, paras. 9.6-9.7, <https://juris.ohchr.org/search/details/654>.

⁴⁵ See, for example, *Garaudy v. France*, 24 June 2003, Application No. 65831/01 and *Honsik v. Austria*, 18 October 1995, Application No. 25062/94, <https://hudoc.echr.coe.int/eng/?i=001-2362>. Европын шүүх Холокостыг үгүйсгэсэн үг яриаг Конвенцын 17 дугаар зүйлд заасан "эрхээ урвуулан ашиглах" гэсэн заалтаар Европын Хүний эрхийн тухай конвенцын 10 дугаар зүйлд (энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалдаг) заасан хамгаалалтаас хасагдсан гэж үздэгийг анхаарна уу.

Холокостыг үгүйсгэсэн хэргүүдийг тусад нь авч үзэхдээ Их танхим тийм баримт нотолгоо шаардлагагүй гэж үзсэн, учир нь Холокостыг үгүйсгэх нь "ямар ч үед" антисемит үйлдэл гэж үзэх ёстой гэж Шүүх хүлээн зөвшөөрсөн юм.⁴⁶

Африкийн хүний эрхийн шүүх мөн геноцидийн хүрээ, хэмжээг багасгахыг хориглосон Руандагийн хуулийн хүрээнд геноцидийг үгүйсгэх асуудлыг авч үзсэн. *Ингабире Виктуар Умухоза Руандагийн эсрэг* шүүх хуралдаанд шүүх улс төрийн сөрөг хүчний гишүүний геноцидийг үгүйсгэсэн хэргийн эрүүгийн ялыг авч үзсэн. Руандагийн геноцидийн хохирогчдын дурсгалын хөшөөний өмнө хэлсэн үгэндээ тэрээр Хуту хохирогчдыг дурсан санахын ач холбогдлын талаар хэлжээ (Руандын геноцид гол төлөв Тутсиг, мөн дундыг баримталсан Хуту нарыг онилсон).⁴⁷ Шүүх Руандагийн түүхийг харгалзан геноцидийг үгүйсгэх хууль нь зөв байж болох ч энэ тохиолдолд тухайн улс төрч геноцидийг үнэхээр үгүйсгэсэн гэсэн шинж тэмдэг байхгүй байгааг тэмдэглэв. Тэрээр үг хэлэхдээ геноцид зөвхөн үндэстэн ястны мөргөлдөөн байсан гэсэн онолыг батлах агуулгаар хэлсэн гэж ойлгох ёстой гэсэн аргументыг Шүүх

хэрэгсээгүй. Мэдэгдэл нь тодорхой байхад "зөвхөн нөхцөл байдлын үндсэн дээр" эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй гэж шүүх тэмдэглэв.⁴⁸ Үүний дараа Африкийн Хүний болон Ард түмний эрхийн комисс Руандагийн хоёр сэтгүүлчийг ялласан талаар тун төстэй дүгнэлт гаргаж, геноцидийг үгүйсгэхийг хориглосон хуулиуд онолын хувьд зөв байж болох ч, тэдний нийтлэлүүд геноцидийг хэрхэн үгүйсгэсэн талаар нотолгоо байхгүй тохиолдолд энэ нь сэтгүүлчдийг яллах үндэслэл болохгүй гэж үзжээ.⁴⁹

Эдгээр хэрэг нь Холокостыг үгүйсгэх нь онцгой тохиолдол байж болох, эсвэл ядаж бусад геноцидийн тухай хууль нь геноцидийг эсвэл ижил төстэй гэмт хэргийг үгүйсгэх явдлыг үзэн ядалтыг өдөөн хатгах хэрэгсэл болгон ашигладаг маш тодорхой соёл, нийгмийн нөхцөл байдалтай холбоотой байх ёстойг харуулж байна. Цаашилбал, ийм хуулиудыг маш нарийн боловсруулж, тэдгээрийг хууль ёсны түүх, эрдэм шинжилгээний мэтгэлцээнд ашиглах, улс төрийн шүүмжлэгчдийн эсрэг, тэр байтугай үзэн ядалтыг өдөөх хэмжээнд хүрэхгүй ч доромжилсон үг хэллэгт хүртэл хэрэглэхээс зайлсхийх ёстой.

⁴⁶ *Perinçek v. Switzerland*, 15 October 2015 Application No. 27510/08, paras. 252-253, <https://bit.ly/3UbgXaN>.

⁴⁷ 24 November 2017, Application No. 003/2014, paras. 151-154, <https://bit.ly/3zOtgJl>.

⁴⁸ *Ibid.*, paras. 158-159.

⁴⁹ *Uwimana-Nkusi & Saidati Mukakibibi v. Rwanda*, 21 October-10 November 2019, Communication No. 426/12, paras. 207-208, <https://www.achpr.org/sessions/descions?id=293>.